ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 22 өдөр Дугаар А/131 Арвайхээр сум

Н.Осоржингийн газар эзэмших эрхийг
Б.Отгонсүрэнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигчийн гаргасан хүсэлтийн дагуу тус сумын Зүлэгт 12 дугаар багийн Зуслан-16 дугаар гудамжны 1630 тоотод байрлах Нямсүрэнгийн Осоржингийн эзэмшлийн 6216035600 нэгж талбарын дугаартай, 28 жилийн эрхийн гэрчилгээний хугацаатай, 500 м2 хэмжээ бүхий, гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай газар эзэмших эрхийг Баасандоржийн Отгонсүрэнд шилжүүлсүгэй.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны "Н.Осоржингийн газар эзэмших эрх шинээр олгох тухай" А/203 дугаар захирамжийн Н.Осоржинтой холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Дээрх газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцсон татварын баримт болон газрын эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг газрын даамал (Л.Цэвэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx

82241315